



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр


Дугаар 2/174

Рашаант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, Сум дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн журмын 6 дугаар бүлгийн 6.2 дахь, Сумын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хэрэгжсэн тэжээлийн нөөцөд өвс нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдсэн ажил, нийлүүлсэн бараа материалыг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч дүгнэлт гаргаж, тайлан балансанд тусгаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.
3. Ажлын хэсгийн үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /С.Аманкелд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.СЕРИКБОЛ